

Лого:
Герман-Монголын Бизнес
Эрхлэгчдийн Холбоо

Герман-Монголын Бизнес Эрхлэгчдийн Холбооны (ГМБЭХ) сонгуулийн журам (СЖ)

2020 оны хоёрдугаар сарын 5-ны өдөр
Удирдах зөвлөлийн 2020 оны хоёрдугаар сарын 5-ны шийдвэр.

Оршил:

Холбооны бүхий л сонгуулийг зарчимч байдал, тэгш байдал, шударга ёсны зарчимд үндэслэн, тус холбооны дүрэмд тусгасан зорилгод нийцүүлэн явуулна.

1-р зүйл

Үндсэн зарчмууд

- (1) ГМБЭХ-с зохион байгуулах сонгуулийг ГМБЭХ-ийн дүрэмд (ГМБЭХ-ийн 2019.03.29-ны өдрийн 8, 11, 13, 14, 23-р зүйл) заасан журам болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу явуулна.
- (2) Саналын эрх бүхий гишүүдийн 1/3-с багагүй хувь юм уу тэдгээрийн төлөөлөл оролцсон тохиолдолд бүх гишүүдийн хурал шийдвэр гаргах чадамжтайд тооцогдоно.

2-р зүйл

Нэр дэвшигч санал болгох

Холбооны Удирдах зөвлөлийн дарга болон гишүүн бүр саналын эрх бүхий энгийн гишүүдийн дотроос Удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвших хүнийг санал болгох эрхтэй. Санал болгосон хүмүүсийн нэрсийг бүх гишүүдийн ээлжит хурлын урилгын хамтаар гишүүдэд илгээнэ.

3-р зүйл

Сонгуулийг удирдан явуулах

- (1) Сонгуулийг хараат бус хүнээр удирдуулна. Уг хүн нь холбооны гишүүн бус байна.
- (2) Сонгуулийг удирдах хүнийг:
 - a) Удирдах зөвлөлөөс сонгон томилж болно.

ЗЕНИТ ОРЧУУЛГЫН ТОВЧОО

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЭТӨЧ, UBH 221
И-мэйл каяг: translationzenith@gmail.com
Утас: 99253703



*Дээрхи баримт бичгийг
Герман хэлнээс Монгол хэл рүү
унэн зөв орчуулсан болно.*

Орчуулагч: С.Мөнхжаргал

- b) Сонгуулийн өмнө бүх гишүүдийн хурал СЖ-ын 3-р зүйлийн 1-д заасан шаардлагыг хангасан этгээдийг хуралдаанд оролцсон гишүүдийн дөрөвний гурваас дээш хувийн саналаар сонгон томилж болно. Энэ тохиолдолд удирдах зөвлөлийн сонгон томилсон сонгууль удирдах этгээдийг татан буугдсанд тооцогдоно.

4-р зүйл

Сонгуулийн ажиллагаа

- (1) Холбооны бүхий л сонгууль өрөнхий, эрх тэгш, чөлөөтэй, шууд, нууц санал хураалтын зарчмаар явагдана.
- (2) Тусгайлан бэлтгэсэн саналын хуудаст нэрийнх нь эхний үсгийг цагаан толгойн дарааллаар байршуулсан нэр дэвшигчид дотроос бичгээр сонголт хийнэ.
- (3) Ердийн гишүүн бүр байршилдаа нийцсэн саналын эрхтэй байна. Нэг нэр дэвшигчид нэг л санал өгөхийг зөвшөөрнө.
- (4) Компани нь Монгол улсад өөрийн төлөөлөгчийн газаргүй гишүүн цахим шуудангаар саналаа өгөх эрхтэй.
- (a) Шуудангаар саналаа өгөхөд шаардлагатай материалыг гишүүдэд сонгууль болохоос 10-с доошгүй хоногийн өмнө олгосон байна.
- (b) Итгэмжлэлийг Удирдах зөвлөлийн даргад бүх гишүүдийн хурал болохоос өмнө ирүүлсэн байна. Саналын хуудсыг монголын цагаар сонгуулийн өдрийн 16 цагаас өмнө сонгуулийг удирдаж буй хүнд ирүүлсэн байна. Уг хугацаанаас хожимдож ирсэн саналыг хүчингүйд тооцно.
- (c) Шуудангаар илгээсэн саналын хуудсыг биечлэн өгсөн саналын хуудастай хамтатган тоолно.
- (d) Монгол улсад төлөөлөгчийн газартай боловч бүх гишүүдийн хурал болох үед төлөөлөгч нь Монголд байгаагүй гишүүд үндэслэлээ тайлбарлаж, тангарагтай ижил хүчинтэй тайлбар гаргасны үндсэн дээр саналаа шуудангаар өгөх хүсэлт тавьж болно. Уг хүсэлтийг хүлээн авах эсэхийг сонгуулийг удирдахаар томилогдсон этгээд шийдвэрлэнэ.

ЗЕНИТ ОРЧУУЛГЫН ТОВЧОО

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЭТӨЧ, UBH 221
И-мэйл кајаг: translationzenith@gmail.com
Утас: 99253703

Дээрхи баримт бичгийг
Герман хэлийэс Монгол хэл рүү
үзүүлэв орчуулсан болно.

Орчуулагч: С.Мөнхжаргал



- (5) Ердийн гишүүн саналын эрхээ өөр ердийн гишүүнд шилжүүлж түүгээр өөрийгөө төлөөлүүлэх эрхтэй. Ингэхдээ тухайн гишүүнд бичгээр үйлдсэн итгэмжлэл олгоно. Ямар ч гишүүн өөр дээрээ таваас дээш саналын эрх (өөрийн саналын эрхийг оролцуулаад) төвлөрүүлэх эрхгүй. Итгэмжлэлийг хурлын даргад сонгууль болохоос өмнө олгоно. Өөр гишүүнд саналын эрхээ шилжүүлэх тохиолдолд эрхээ шилжүүлсэн гишүүний саналаа шуудангаар өгөх эрх хүчингүй болно.
- (6) Олонхийн санал авсан нэг нэр дэвшигч сонгогдсонд тооцогдоно. Хэрэв хэд хэдэн албан тушаалд зориулж сонгууль явуулж байгаа бол хамгийн олон санал авсан дараагийн нэр дэвшигч мөн сонгогдсонд тооцогдох ба бүх ажлын байр эзлэгдэж дуусах хуртэл уг зарчмаар сонгоно.
- (a) Санал тэнцсэн тохиолдолд дахин сонгууль явуулна.
- (b) Кассын хянагчид нэмэлт шалгуур (ГМБЭХ-ийн 2019.03.29-ны өдрийн дүрмийн 23-р зүйл) тавигдах бөгөөд холбооны дүрэмд заасан тухайн албан тушаалд тавигдах бусад нэмэлт нөхцлийг харгалзаж болно.
- (7) Саналын хуудас дээр сонгох шаардлагатай тооноос олон нэр дэвшигчийг тэмдэглэсэн, нэг нэр дэвшигч дээр нэгээс олон санал өгсөн, саналын хуудас дээр нэмэлт тэмдэглэгээ хийсэн зэрэг тохиолдолд тухайн саналын хуудас хүчингүйд тооцогдоно.
- (8) Санал тоолох ажиллагаа ил явагдана.

5-р зүйл

Сонгууль хүчинтэйд тооцогдох

- (1) Сонгуулийг удирдах эрх бүхий этгээд саналын хуудсыг тоолж дуусмагц сонгуулийн үр дүнг хуралд шууд танилцуулна. Хэрэв сонгогдсон нэр дэвшигч сонгуулийн үеэр өөрийн биеэр байгаагүй бол хурлын дарга түүнд сонгогдсон тухай нь захидалаар юм уу цахим шуудангаар мэдэгдэнэ.
- (2) Биечлэн ирсэн сонгогдогч сонгуулийн үр дүнг танилцуулмагц үр дүнг хүлээн зөвшөөрч байгаагаа хуралд оролцогчдод илэрхийлнэ.
- Шинээр сонгогдсон Удирдах зөвлөл нь бүх гишүүд нь бүрэн хэмжээгээр бүрэлдсэний дараа л өөрийн ажлыг албан ёсоор хүлээн авсанд тооцогдоно. Удирдах зөвлөлийн гишүүд дундаасаа Удирдах зөвлөлийн даргыг сонгоно. Санал тэнцсэн тохиолдолд сугалаагаар шийдвэрлэнэ.

ЗЕНИТ ОРЧУУЛГЫН ТОВЧОО

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЭТӨЧ, UBН 221
И-мэйл хаяг: translationzenith@gmail.com
Утас: 99253703

Дээрхи баримт бичгийг
Герман хэлнээс Монгол хэл рүү
үнэн зөв орчуулсан болно.

Орчуулагч: С.Мөнхжаргал



6-р зүйл

Сонгууль явуулах журмыг өөрчлөх

- (1) Сонгууль явуулах журмыг холбооны удирдах зөвлөл 4/5 хувийн саналаар өөрчилж болно.
Өөрчлөлтийн талаар нийт гишүүдэд даруй мэдэгдэнэ.
- (2) Сонгууль явуулах журмыг шийдвэр гаргах чадамж бүхий бүх гишүүдийн хурал оролцсон буюу төлөөлөл бүхий гишүүдийн дөрөвний гурван хувийн саналаар өөрчилж болно.
Сонгууль явуулах журмыг бүх гишүүдийн хурлаар өөрчилсөн тохиолдолд СЖ-ийн 6-р зүйлийн 1-р заалтад тусгасан процедурыг явуулахгүй.

7-р зүйл

Протокол / сонгуулийг өндөрлөх

- (1) Бүх гишүүдийн хурлын явц, санал хураалтын дүнгийн талаар протокол хөтөлж холбооны тэргүүн болон удирдах зөвлөлийн гүйцэтгэх удирдлагаар гарын үсэг зуруулна.
- (2) Протоколд дараах мэдээллийг тусгана:
 - (a) Сонгууль бүхий хурал болсон газар, цаг
 - (b) Оролцогчдын тоо
 - Хуралд оролцсон ердийн гишүүдийн тоо
 - Захиргааны төлөөлөл
 - Төлөөлж буй гишүүд болон төлөөлүүлсэн гишүүдийн нэрс
 - Бусад
 - (c) Сонгуулийг удирдан явуулахаар томилогдсон этгээд
 - (d) Нэр дэвшигчид
 - (e) Сонгуулийн үр дүн
 - (f) Сонгогдсон гишүүд сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрч сонгуульт ажлыг хүлээн авахаа илэрхийлсэн эсэх
 - (g) Сонгуулийг удирдан явуулсан хүний гарын үсэг
- (3) Сонгуулийн саналын хуудас, төлөөлөх эрх олгосон итгэмжлэл зэрэг бичиг баримтуудыг тус холбооны захиргааны хэлтэст нэг жилийн турш хадгална.

ЗЕНИТ ОРЧУУЛГЫН ТОВЧОО

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЭТӨЧ, UBН 221
И-мэйл хаяг: translationzenith@gmail.com
Утас: 99253703



Дээрхи баримт бичгийг
Герман хэлнээс Монгол хэл рүү
үнэн зөв орчуулсан болно.

Орчуулагч: С.Мөнхжаргал